



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” А/26 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.2.4, 4 дүгээр зүйлийн 4.7.6, төвийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулатын журам” -ыг нэгдүгээр, “Шалгалтын дүнгийн хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулатын журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Б.Байгалмаа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, удирдлагын алба (Л.Оюунчимэг) –д даалгасугай.

ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

132300000250

ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд төвийн хэмжээнд бий болсон сул орон тоо, албан тушаалд чадварлаг, ёс зүйтэй иргэнийг сонгон шалгаруулж авах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам” /цаашид “журам” гэх/-ын зорилго оршино.
- 1.2. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим:
 - 1.2.1. хууль дээдлэх;
 - 1.2.2. шударга, нээлттэй, ил тод байх;
 - 1.2.3. үндэс угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн байгууллагын харьяалал зэргээр ялгаварлах, хязгаарлах, давуу байдалд тогтоохгүй байх;
 - 1.2.4. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.3. Дараах тохиолдолд иргэний сонгон шалгаруулалтад орох эрхийг хязгаарлана.
 - 1.3.1. шүүхийн шийдвэрээр ял эдэлж байгаа, ялын хугацаа нь дуусаагүй;
 - 1.3.2. эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдон цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа;
 - 1.3.3. зарлагдсан ажлын байртай ижил төрлийн ажлын байран дээр ажиллаж байгаад ёс зүйн зөрчил гаргаж, сахилгын шийтгэлээр ажлаас халагдсан, түр хугацаагаар ажиллах эрхийг түдгэлзүүлсэн, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон;
 - 1.3.4. харьяалалгүй иргэн.

Хоёр. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

- 2.1. Тус төвийн удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагч болон тус төвд шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн иргэдээс нөхөх ажлыг зохион байгуулна.
- 2.2. Удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог дараах дарааллаар нөхнө.
 - 2.2.1. тус төв болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;
 - 2.2.2. энэ журмын 2.2.1-д заасны дагуу нөхөх боломжгүй бол тус төвийн нөөцөд байгаа иргэдээс;
- 2.3. Удирдах албан тушаалын сул орон тоонд тухайн албан тушаалын албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагыг хангасан төрийн албан хаагч

дараах шаардлагыг хангасан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу албан тушаалд томилогдох боломжтой.

2.3.1. сүүлийн гурван удаагийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “Маш сайн”, “Сайн” гэсэн үнэлгээ авсан байх;

2.3.2. сүүлийн 12 сарын хугацаанд ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.4. Энэхүү журмын 2.2-д заасан нөөцөөс сул ажлын байр нөхөгдөөгүй тохиолдолд ажлын байрны зарыг нийтэд мэдээлж, сонгон шалгаруулалт зохион байгуулан хүний нөөцийг бүрдүүлнэ.

2.5. Сул ажлын байрны зарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон боломжит мэдээллийн доорхи сувгуудаар нийтэд ил тод мэдээлнэ.

- Байгууллагын цахим хуудас;
- Байгууллагын нүүр хуудас;
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл.

2.6. Сул ажлын байрны зард дараах мэдээллийг оруулсан байна.

- Албан тушаалын нэр;
- Ажлын байрны үндсэн чиг үүрэг;
- Ажлын байранд тавигдах шаардлага;
- Бүрдүүлэх материал;
- Бүртгэх хугацаа;
- Холбоо барих утас, хаяг байршил, цахим шуудангийн хаяг.

2.7. Сонгон шалгаруулалтад орох иргэн дараах материалыг бүрдүүлэн холбогдох албан хаагчид ирүүлсэн байна. Үүнд:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг / хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;
- Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэр, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт;
- Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;
- Ажилд орохыг хүссэн өргөдөл.

2.8. Шалгалт зохион байгуулах үүрэг бүхий комиссыг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр төвийн захирлын тушаалаар тухай бүр байгуулна.

2.9. Шалгалтын комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.9.1. гишүүдийн ажил үүргийн хуваарь, шалгалттай холбогдох аливаа асуудлыг хуралдаж хэлэлцэн шийдвэрлэх;

2.9.2. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хараат бус шийдвэр гаргах;

2.9.3. анкет, холбогдох бусад материалыг цаасаар болох цахимаар хүлээн авах;

2.9.4. шалгалт авах танхим, техник хэрэгсэл, холбогдох бэлтгэлийг хангах, зохион байгуулах;

2.9.5. бүртгэл, зохион байгуулалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх;

2.9.6. шалгалтын тайлан, холбогдох материалыг төвийн захиралд хүргүүлэх;

2.9.7. зарлагдсан ажлын байрны албан тушаалын тодорхойлолттой танилцах, тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг хянах;

2.9.8. ур чадвар /цогц чадамж/-т суурилсан ярилцлагын шалгалт зохион байгуулах, үнэлгээ өгөх.

2.10. Комиссын хурлын шийдвэрийг тэмдэглэлд тусгана. Тэмдэглэлийг зохих журмын дагуу хөтөлж, гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Сонгон шалгаруулалтын үе шат

3.1. *Анкетын шалгаруулалт:*

3.1.1. анкетын шалгаруулалт хийхдээ зарласан ажлын байранд тавигдах шаардлагад нийцэж байгаа эсэхийг харгалзан үзнэ.

3.1.2. иргэн анкет болон бусад материалаа цахим хэлбэрээр болон биечлэн ирүүлж болох ба анкетын шалгаруулалтад тэнцсэн эсэх тухай мэдээллийг ажил олгогчоос тухай бүр мэдэгдэнэ.

3.2. *Ерөнхий шалгалт:*

3.2.1. энэ журмын 3.1-т заасан анкетын шалгаруулалтад тэнцсэн иргэнээс ерөнхий мэдлэг, монгол хэл бичгийн чадвар, дүн шинжилгээ хийх чадварын (сэтгэхүйн чадамж) шалгалт авна. Зарлагдсан ажлын байранд гадаад хэлний мэдлэгийн ур чадварын тусгай шаардлага тавигдсан тохиолдолд тухайн гадаад хэлээр сургалт нь явагддаг бүрэн дунд, их, дээд сургууль, коллеж төгссөн, магистр, докторын зэрэг хамгаалсан бол боловсролын баримт бичиг эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгддөг тухайн хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн бол уг иргэний түүнд холбогдох баримт бичгийн оноог үндэслэн гадаад хэлний мэдлэгийн тусгай шаардлага хангасан эсэхийг тогтооно.

3.2.2. ерөнхий мэдлэгийн шалгалтыг сорилоор шалгаж 40 хүртэлх оноогоор үнэлэх бөгөөд хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх мэдлэгийг 20, цахим орчин, компьютерын хэрэглээний программ ашиглах талаарх мэдлэгийг 10, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналт, үнэлгээний талаарх мэдлэгийг 10 хүртэл оноогоор тус тус дүгнэнэ. Энэхүү шалгалтаар 24 ба түүнээс дээш оноо авсан иргэн дараагийн шалгалтад оролцох эрхтэй.

3.2.3. монгол хэл, бичгийн чадварын шалгалтад кирилл бичиг, үндэсний бичгийн талаарх мэдлэг болон чадварыг сорилоор шалгаж 30 хүртэл оноогоор үнэлнэ. Энэхүү шалгалтаар 18 ба түүнээс дээш оноо авсан иргэн дараагийн шалгалтад оролцох эрхтэй.

3.2.4. дүн шинжилгээ хийх чадварыг сорилоор шалгаж 30 хүртэл оноогоор үнэлнэ. Энэхүү шалгалтаар 18 ба түүнээс дээш оноо авсан иргэн дараагийн шалгалтад оролцох эрхтэй.

3.2.5 ерөнхий мэдлэг, монгол хэл, бичгийн чадвар, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад нийтдээ 60 болон түүнээс дээш оноо авсан иргэнийг шалгалтад тэнцсэнд тооцно.

3.3. Ярилцлага хийх:

3.3.1. шалгалтад тэнцсэн иргэнийг хүний нөөц хариуцсан мэргэжилтэн ярилцлагад урина.

3.3.2. ярилцлагыг төвийн захирлын тушаалаар байгуулагдсан комисс зохион байгуулна.

Дөрөв. Нэр дэвшүүлэх

4.1. Шалгалтын комисс нь шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан оролцогчийг тухайн албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ.

4.2. Нэг албан тушаалд өрсөлдсөн оролцогчдын шалгалтын нийт оноо тэнцвэл бүрэлдэхүүн шалгалт тус бүр дээр өндөр оноо авсан байдлыг харгалзан дарааллыг тогтооно.

4.3. Нэр дэвшигч өөрийн хүсэлтээр томилогдохоос татгалзсан эсхүл мэдэгдсэн хугацаанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 14 хоног хэтэрсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдоос онооны дарааллыг батимтлан нэр дэвшүүлнэ.

4.4. Нэр дэвшигчийг томилохоос өмнө төрийн албаны тухай хуулийн 22.1.5-д тавигдсан сэтгэцийн өвчин, эмгэггүй байх гэсэн шаардлагыг хангаж байгаа тухай баримтыг эрүүл мэндийн байгууллагаас, удирдах албан тушаалд нэр дэвшигчээс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д заасан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраас авсан байна.

4.5. Шалгалтын комисс шалгалтад тэнцсэн иргэдийг нөөцөд бүртгэсэн тухай шийдвэртээ тэмдэглэнэ.

Тав. Шийдвэр гаргах

5.1. Төвийн захирал шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажилд авсан тухай тушаал гаргана.

5.2. *Ажилд авсантай холбогдуулан хийгдэх ажлын үе шатууд:*

5.2.1. ажилд авах тухай тушаал боловсруулж, батлуулах;

5.2.2. хөдөлмөрийн гэрээ болон холбогдох бусад гэрээг /эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, нууцын гэрээ гм/ байгуулах;

5.2.3. байгууллага хамт олонд танилцуулах;

5.2.4. шинэ ажилтны сургалтад хамруулах;

5.2.5. туршлагатай албан хаагчид дадлагажуулан сургах;

5.2.6. туршилтын 3 сарын хугацаанд үр дүнтэй ажилласан бол жинхлэх асуудлыг шийдвэрлэх;


5.2.7. хөдөлмөрийн харилцааны бусад асуудал.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын
2023 оны .11. дүгээр сарын 23 ны өдрийн
А/07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Шалгалт өгсөн иргэний:
Регистрийн дугаар:
Ургийн овог:
Эцэг /эх/-ийн нэр:
Өөрийн нэр:



№	Шалгалтын бүрэлдэхүүн	Авбал зохих дээд оноо	Авсан оноо
1	Ерөнхий мэдлэг	40	
2	Монгол хэл, бичгийн чадвар	30	
3	Дүн шинжилгээ хийх чадвар	30	
Нийт оноо		100	

202..... оны сарын-ны өдөр